

**“МОСКВА ГУРАВ ДАХЬ РОМ” ГЭСЭН УЛС ТӨРИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙД**

Ж.ЖАРГАЛ

Доктор, МУБИС-ийн багш

Түлхүүр үг: Оросын улс төрийн сэтгэлгээ, христын шашны улс төрийн номлол, Киевийн орос, төвлөрсөн төр улс, Ромын эзэнт гүрэн, Москвагийн вант улс, улс төрийн илтгээлт бичиг, шашин төрийг хослох ёс.

Abstract: In this article author analyzed political concept “Moscow – the Third Rome”. This doctrine emerged in XVI century. Filofei was a hegumen of the Yelizarov Monastery near Pskov in the 16th century. He is credited with authorship of the Third Rome prophecy. Details of which are very scarce. Known as the presumed author of the concept of «Moscow - the Third Rome», which sets out the thesis in his letters.

Дэлхий дахины улс төрийн сэтгэлгээний түүхэнд оросын улс төрийн сэтгэлгээ өөрийн зохих байр суурийг эзэлдэг. Түүнийг холбогдох эх зохиол, сурвалж бичгүүдэд тулгуурлан сайтар судлах явдал нь манай хөрш Орос орон, Оросын ард түмний түүх, нийгмийн сэтгэлгээ, оюуны соёлыг танин мэдэхэд зохих ёсны ач холбогдолтой юм.

Бид энэхүү өгүүлэлд “Москва гурав дахь Ром” гэсэн улс төрийн үзэл баримтлал үүсэж боловсрогдох болсон түүхэн нөхцөл, тэр үеийн онцлог, үзэл санааны урьдач нөхцөл, эл баримтлалыг үндэслэж гаргасан сэтгэгч Филофейн намтар, үзэл баримтлалын агуулга, голлох үзэл санааг тоймлон өгүүлэх зорилт тавьсан болно.

Энэ асуудлаар Орос болон бусад гадаад хэлээр олон тооны ном бүтээл гарсан байгаа боловч тэдгээрээс манай орны төвийн номын сангуудад цөөн тооны хэдхэн ном бүтээл байгаа ба өргөн ашиглах ном зохиол хомс юм.

Өгүүлэлд гол эх сурвалж болгож Филофей ламын улс төрийн үзэл санаа тусаж илэрхийлэгдсэн “Загалмайн бэлгэ тэмдгийг залруулах хийгээд хэрээс хэтэрсэн самуун явдлын тухай Агуу их Ван Василийд илгээх бичиг” хэмээх сурвалж бичгийг эх хэлээр нь ашиглав. Энэхүү илгээлт бичиг XVI зууны үеийн Орос хэлээр, шашны утга зохиолын хэл найруулгаар бичигдсэн, хуучирсан, утга агуулга нь бүдэг, тодорхой бус үг хэллэг цөөнгүй байгаа зэрэг нь эл бичгийн утга санааг бүрэн гүйцэд монголчилж ойлгоход багагүй бэрхшээлтэй байгааг дурдья.

“Москва гурав дахь Ром” гэсэн улс төрийн үзэл баримтлал Москвагийн Вант улсын үед, XVI зууны эхний хагаст үүсэн боловсрогджээ. Оросын судлаач эрдэмтэд Москвагийн Вант улсын түүх нь 1276 оноос эхэлсэн гэж үздэг. Оросын тархай бутархай феодалын жижиг Вант улсуудын дотроос Москва 1276 онд анх удаа бие даасан Вант улс болж аажмаар Оросын бусад газар нутгуудыг өөртөө нэгтгэх болжээ. Москвагийн Вант улсыг Оросын үнэн алдрын шашин, сүм хийд ч дэмжиж байв. XIY зууны хоёрдугаар хагасаас Москвагийн Вант улс бэхжиж түүнийг энэ үеэс эхэлж “Агуу их Орос улс” (Великая русь) гэж нэрлэжээ. Их Ван гурав дахь Иван (1462-1502), түүний дараах Василии (1505-1533) нарын засаглалын үед Москвагийн Вант улс бэхжих, түүнийг тойрч Оросын бусад газар нутаг, жижиг Вант улс нэгдэж нягтрах, феодалын задрал, бутралыг даван туулах үйл явц идэвхтэй явагджээ. Улс төрийн сэтгэгч лам Филофей чухамдаа Василий Ванд өөрийн илгээлт бичгийг илгээж түүндээ улс төрийн үзэл бодлоо илэрхийлсэн байна.

XV зууны дунд үеэс Алтан орд улс хүч суларч задрах болсон явдал Москвагийн Вант улс цаашдаа улам бэхжиж хүчирхэг болох таатай нөхцлийг бүрдүүлжээ. Москвагийн Вант улс XIV-XV зуунд бүх эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн эзэн хаанаар удирдуулсан, нэгдмэл хүчирхэг төр улс болж хувирсан байна.

Москвагийн Вант улсын үеийн нийгэм, улс төрийн сэтгэлгээний хөгжил, шинж чанарт христын шашны гурван том урсгал чиглэлийн нэг болох үнэн алдрын шашин, түүний сүм хийд багагүй нөлөөтэй байв. Орос орон христын шашныг 988 онд Киевийн Оросын Ван Владимирийн хүчин чармайлт, санаачилгаар хүлээн авч нийт Оросуудын шашин шүтлэг болгож шүтэн баримталж эхэлжээ. Гэхдээ энэ нь нийт Орос орон даяар христын шашныг нэн даруй шүтэн баримтлах болсон гэсэн үг биш

байв. Орос орны хойд бүс нутаг, Новгород, Муром зэрэг хот, газар нутгийн хүн ард христын шашныг эсэргүүцэж хуучны шүтлэгтэй байсаар иржээ.

Христын шашны үнэн алдрын урсгалын гол төв нь Византи гүрэн байв. Орос оронд үнэн алдрын шашин Византи улсаар дамжиж нэвтрэн дэлгэрчээ. Гэтэл Византи гүрэн 1453 онд Туркийн довтолгооноор (Османы эзэнт гүрний байлдан дагуулалар) нуран унаж бие даасан гүрэн байхаа больсноор үнэн алдрын шашин, сүм хийдийг дэмжиж түшигч улс гүрэн бол Москвагийн Вант улс болсон байна. Үнэн алдрын шашны нэг чухал онцлог, католик болон протестант шашнаас ялгагдах ялгаа нь тэрээр төр улсыг, эзэн хааны засаглалыг дэмжин түшиж тулдаг явдал байв. Энэ нь Москвагийн Вант улсын үеийн Оросын улс төрийн сэтгэлгээнд, тэр дотор “Москва гуравдахь Ром” гэсэн улс төрийн үзэл баримтлалд шууд нөлөөлж тусгалаа олжээ.

Тийнхүү “Москва гуравдахь Ром” гэсэн улс төрийн үзэл баримтлал үүсэж боловсрогдох үеийн буюу XVI зууны эхэн үеийн түүхэн нөхцөл дэх гол зорилт бол Орос орны нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдарлын задрал бутралыг даван туулж Москва төвтэй хүчирхэг, эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн эзэн хаантай, төвлөрсөн төр улсыг бэхжүүлэх явдал мөн байв. Чухам энэхүү нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын оюун санаа, сэтгэлгээний улс төрийн илэрхийлэл болж “Москва гуравдахь Ром” гэсэн улс төрийн үзэл баримтлал гарч ирсэн байна.

Энэхүү үзэл баримтлал үүсэж боловсрогдоход тэр үеийн Оросын нийгэм-улс төр, философи сэтгэлгээ, түүний уламжлал, голлох үзэл санаа ч багагүй нөлөөлжээ. Оросын судлаач эрдэмтэд, тухайлбал, оросын улс төрийн сэтгэлгээний түүхийн мэргэжилтэн эрдэмтэн профессор Н.М. Золотухина XVI зууны үеийн оросын улс төрийн сэтгэлгээний хөгжилд өмнөх үеийн, тэр дотор эртний оросын бичиг соёл, Византи ба Славян, Европын ард түмнүүдийн соёл, нийгмийн сэтгэлгээ, тэдгээрийн уламжлал, ололт амжилт чухал нөлөөтэй, ихээхэн ач холбогдолтой байсныг зааж тэмдэглэжээ (4,189). XV-XVI зууны үеийн Оросын нийгэм-улс төрийн сэтгэлгээний төвд тавигдаж хариу тайлбар гарсан, маргаан үүсгэж байсан гол асуудлууд бол Оросын төр улс, эзэн хааны засаглалын гарал үүсэл, Ван, хаадын удам угсааны гарал, түүх, төрийн засаглалын дээд эрх мэдлийг хэрхэн яаж зохион байгуулж хэрэгжүүлэх тухай, үнэн алдрын шашин, сүм хийд ба төр засаг хоорондоо хэрхэн харилцах тухай асуудлууд байжээ.

XV зууны сүүлч үеэс эхэлж оросын улс төрийн сэтгэлгээнд үнэн алдрын сүм хийдийн эдийн засгийн байр суурь, газар өмчлөх эрх, сүм хийдийн эзэмшил газарт тариачдын хүч хөдөлмөрийг ашиглах, сүм хийд улс орны улс төрийн амьдралд оролцох асуудал чухалаар тавигдсан байна. Эдгээр асуудалд хандах, хариу тайлбар өгөх явцад «жавшихуй», “шунахуй» (стяжательство) «үл жавшихуй», “үл шунахуй» (нестяжательство) гэсэн нийгэм-улс төрийн үзэл санааны үндсэн хоёр урсгал чиглэл гарч иржээ. Нэгдэх нь үнэн алдрын сүм хийдийн тэр үеийн зохион байгуулалт, эдийн засгийн эрх ашиг, байр суурь, газар өмчлөх эрхийг нь хэвээр нь хадгалахыг зөвтгөж байсан бол хоёрдахь урсгал чиглэл нь түүний эсрэг байв. Филофей лам нэгдэх үзэл санааг баримталж байв.

«Москва гурав дахь Ром» нэртэй улс төрийн үзэл баримтлалыг үндэслэгч гэж тооцогддог Филофей ламын намтар нь балархай, үйл ажиллагаа, амьдралын талаархи мэдээ баримт тун бага ажээ. Холбогдох ном бүтээлд тэрбээр 1465-1542 оны үед амьдарч аж төрж байсан, Псковын Елеазарын сүмийн ширээт лам (игумен) байсан талаар дурьджээ. Филофей өөрийнхөө талаар зарим зүйлийг дурьдаж бичсэн бөгөөд тэдгээрт «миний бие хөдөө тосгоны хүн мөн бөгөөд бичиг үсэгт суралцаж тайлагдсан, гэхдээ уран илтгэх ухаан, астрономын ухааныг уншиж судлаагүй, цэцэн мэргэн ухаантай философичидтой харилцан ярилцаж байсангүй» гэж төлөв дарууханаар бичжээ. Энэ нь тэр үеийн оросын бичиг номын хүмүүс өөрсдийгөө магтаж дөвийлгөдөггүй, даруу төлөв, жижиг, өчүүхэн хүн болгож илтгэдэг байсан уламжлалтай нягт холбоотой болохыг судлаач эрдэмтэд тэмдэглэж бичсэн байна. (4,198).

Филофейг таньдаг, мэддэг байсан тэр үеийн бичиг номын зарим хүмүүс түүний талаар бичсэн зүйлээс ганц нэг мэдээ бичиг хадгалагдан үлдсэнээс үзвэл Филофей лам сүмд байнга оршин амьдардаг (“тэрхүү өвгөн лам сүмээс гардаггүй байсан” гэжээ), эрдэм боловрол өндөр, бичиг номонд нэвтэрхий (“премудрости словес знаем”) байсан хэмээжээ. Филофейн түүх намтарыг бичсэн, нэр нь үл мэдэгдэх нэгэн бичиг номын хүн Филофей лам зоригтой, үнэнийг шууд хэлдэг, хоёр нүүр гаргадаггүй, Ван, Хаан, Бояр, Амбан захирагчдын алдаа дутагдлыг илэн далангүй илчилж гаргаж хэлдэг байсан талаар бичжээ.

Филофей өөрийнхөө нийгэм-улс төрийн үзэл санаагаа Москвагийн Вант улсын Ван гуравдугаар Василий Ивановичид бичиж илгээсэн анхны илгээлт бичигтээ илэрхийлж томъёолсон бөгөөд түүнийгээ дараа нь Василий Вангийн үеийн улс төрийн зүтгэлтэн байсан М.Г. Мунехинд (1528) илгээсэн бичигтээ улам тодруулан дэлгэрүүлж гаргажээ. Филофейн илгээлт бичгүүдэд тусгагдсан улс төрийн үзэл баримтлалыг хожим нь «Москва гуравдахь Ром» хэмээн нэрлэх болсон болохоос биш

Филофей өөрийн үзэл баримтлалаа тийнхүү нэрлэж байгаагүй ажээ.

Филофейн улс төрийн үзэл баримтлалын талаар гарсан ном бүтээлд энэхүү үзэл баримтлал нь теократ буюу шашин төрийг хослон барих тухай үзэл баримтлал уу эсвэл шашинтай холбоогүй, дан улс төрийн утга агуулгатай юу, эл үзэл баримтлал XVI зууны үеийн Оросын төр улсын албан ёсны үзэл суртлын үндэс болж байв уу, үгүй юу, тэр үеийн албан ёсны улс төрийн бодлого, улс төрийн бодит амьдралтай нийцэж байв уу, эсвэл сөргөлдөж байв уу, эл үзэл баримтлал Орос улс бусад улс орныг эзлэн түрэмгийлэхийг зөвтгөсөн санаа бодлыг агуулсан уу, үгүй юу гэх зэрэг асуултууд тавигдаж тэдгээрт зохих хариу тайлбар өгөгдсөн байна. Судлаач эрдэмтэд Филофейн энэхүү үзэл баримтлал бол ерөнхий утга агуулга, үзэл санаагаараа шашны историософи буюу шашны утга агуулгатай түүхийн философийн чанартай бөгөөд Орос улс бол Христос бурханы онцгойлон таалж сонгосон, дэлхийд онцгой байр суурь эзэлж, чухал үүрэг гүйцэтгэх улс орон, Ром ба хоёр дахь Ром болох Византийн дараахь христын шашин, тэр дотор үнэн алдрын шашны цорын ганц, жинхэнэ бөгөөд хамгийн сүүлчийн төв бүхий хамгаалан өмгөөлөгч цайз мөн гэсэн үзэл санааг агуулсан гэж үздэг байна. (1.149).

Филофейн үзэл баримтлал жинхэнэ теократ үзэлтнүүд ба “жавшихуйн” үзэл санааг тууштай баримтлагч иосифлянчуудын үзэл санаанаас ялгаатай бөгөөд энэ ялгаа нь Филофей төр, төрийн засаглал нь сүм хийдийн дээгүүр байх ёстой, өөрөөр хэлбэл сүм хийд нь төрд захирагдах ёстой гэж үздэгт оршино. Гэвч судлаачид Филофейн үзэл баримтлалд теократ үзэл санаа тодорхой хэмжээгээр агуулагдсан гэж үздэг байна. (1.149). Түүний нотолгоо бол үнэн алдрын сүмийн дэлхий дахинд гүйцэтгэх түүхэн үүргийн хэрэгжин биелэгдэх гол хүч бүхий хэрэгсэл бол төрийн тэргүүн эзэн хаан мөн гэж Филофей үзсэн явдал мөн болно.

Филофейн шашин-улс төрийн үзэл баримтлал XVI зууны нөхцөлд практикийн болон оюун санааны багагүй ач холбогдолтой байжээ. XVI зуунд Османы эзэнт гүрэн (Турк гүрэн) хүчирхэгжиж, Византи гүрнийг эзлэн авч нураасан, христын шашинтай Европын орнуудад аюул занал учруулах болсон бөгөөд ийм нөхцөлд Баруун европын орнуудын улс төрчид улам бүр бэхжиж, өөдлөн дээшилж буй Москвагийн Вант улсад анхаарал хандуулж энэ улс нь нурж унасан Византи гүрний залгамжлагч мөн гэж үзэхийн хамт Москвагийн Вант улсыг Туркийн эсрэг зэвсэгт мөргөлдөөн, дайнд өдөөн турхирах санаа бодолтой байжээ. Ийм нөхцөлд Москвагийн вант улс бэхжиж хүчирхэгжих, христын шашинт улс орнуудыг эл шашны үзэл санааны тугийн дор нэгтгэн нягтруулах, улмаар нэгдмэл хүч, фронтоор Туркийн эсрэг тэмцэлд хөдлөхөд бэлтгэхэд Филофейн үзэл баримтлал оюун санааны хувьд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн ажээ.

Оросын судлаач эрдэмтэд Филофейн нийт гурван удаагийн илгээлт бичгийг хооронд нь харьцуулан судалж тэдгээрийн үзэл санааг гаргаж тавьсны үндсэн дээр Филофейн өөрийнх нь улс төрийн үзэл санаа ба түүний үндсэн дээр хожмын үед сэлбэн засагдаж, нэмэгдэж боловсрогдсон “Москва гурав дахь Ром” гэсэн улс төрийн үзэл баримтлалын ялгаа ба нийтлэг үзэл санааг гаргасан байна. Тухайлбал, профессор О.Э. Лейстийн редакцийн дор гарсан “История политических и правовых учений” (М.2000.Г) хэмээх сурах бичигт Филофейн илгээлтүүдийн улс төрийн гол үзэл санаа бол “Ромейн хаанчлал”-ын тухай үзэл санаа мөн гэж заажээ (5,156).

Филофейн үзэл ёсоор “Ромейн хаанчлал” бол бодитой оршин буй хаант засаг, төр улс биш, харин үлгэр жишээч төрийн тухай хэм хэмжээлэг үзэл санаа ажээ. Тиймээс Филофей “Ромейн хаанчлал”-ыг нэгдүгээр ром буюу эртний үеийн Ромын эзэнт гүрэн, хоёрдахь Ром гэгдэх Византи гүрэнтэй адилтгаж үзээгүй ажээ. Филофейн үзлээр “Ромейн хаанчлал” нь ирээдүйд Орос оронд төлөвшин тогтож, бэхжин хүчирхэгжих ёстой бурхны хаанчлал бүхий христын шашинтай төр улс ажээ. Филофей энэхүү саналааг, үлгэр жишээч, төгс төрийг “Ромейн хаанчлал” гэж нэрлэсэн шалтгаан бол чухамдаа эртний үеийн Ромын эзэнт гүрэнд христосын шашин ба төрийн засаглал хоёр анх удаа хоорондоо халбогдож эвссэн гэж тэрбээр үзжээ. Христын шашин ба төрийн засаглал хоёр тийнхүү нийлж, бие биеэ түшин дэмжсэнээр онцгой хүчин чадлыг олох ажээ. Ромейн хаанчлал эвдэршгүй, бат бэх, мөнх юм. Гэтэл түүхэнд бодитой оршин байсан төр улсууд, тэр дотор Ромын эзэнт гүрэн ба Византи гүрэн Ромейн хаанчлалын дүр зураг, санааг ямар нэг хэмжээгээр тээж авч явсан боловч бүрэн бүтэн байдлаар хэрэгжүүлэн биелүүлж чадаагүй, бас тодорхой шалтгаануудаар нурж унасан гэж Филофей үзжээ. Эл хоёр гүрэн нурж унасаны дараа Ромейн хаанчлалын дүр зураг, үзэл санаа Москвагийн вант улсад уламжлагдан өвлөгдсөн ажээ. Гэхдээ Москвагийн вант улс бол эртний үеийн Ром гүрэн ба Византи гүрний шууд, бодитой залгамжлагч нь биш, харин үнэн алдрын шашинтай христын төр улсын үзэл санаа, эрхэмлэлийг тээж авч явагч, түүнийг XVI зууны шинэ нөхцөлд бүрэн төгс хэрэгжүүлэн биелүүлэх хувь тавилантай, түүхэн үүрэгтэй төр улс мөн ажээ.

Энэ нь Оросын төр улс эртний үеийн Ром, хожмын үеийн Византи гүрэн шиг эд баялаг, харгислал, зэвсэг, цэргийн хүчин чадалд тулгуурласан эзэнт гүрэн байх ёстой гэсэн үг биш, харин үнэн алдрын шашин, оюун санааны үнэт зүйл, эрхэмлэлд тулгуурласан Ариун Орос орон (Святая Русь) байх ёстой гэсэн үг ажээ.

Филофей Ромейн хаанчлал буюу үнэн алдрын шашин ба хаант төр хослосон үлгэр жишээч, төгс, санаалаг төр улсын үзэл санааг хэрэв Орос улс хэрэгжүүлэн биелүүлж үл чадах аваас эл үзэл санааг хожим нь дэлхийд ямар нэг өөр улс гүрэн уламжлан авч хэрэгжүүлж чадахгүй, гэхдээ тухайн үзэл санаа мөнх оршоор байх болно гэж үзжээ. Филофейн эдгээр үзэл санаанд чухамдаа Москвагийн вант улс л гуравдахь Ром байх ёстой, тийм түүхэн үүрэгтэй, гэхдээ үнэн алдрын шашны хүчин чадал, гэрэл гэгээ, онцгой нөлөөнд тулгуурласан ариун бөгөөд цоо шинэ Ром байх ёстой гэсэн ерөнхий үзэл санаа агуулагдсан байна. Тийм учраас хожмын XVI-XVII зууны үеийн Оросын нийгэм-улстөрийн сэтгэлгээ Филофейн улс төрийн үзэл санааг сэлбэн баяжуулж, түүний үндсэн дээр “Москва гуравдахь Ром” гэсэн улс төрийн үзэл баримтлалыг боловсруулж дэвшүүлэн тавьсан байна.

Филофей өөрийнхөө илгээлт бичгүүдэд нийгэм-улс төрийн дараахь үндсэн, гол үзэл санаануудыг гарган илэрхийлжээ. Тэдгээр нь нэгдүгээрт, тодорхой хэлбэл Москвагийн их Ван Василий, ер нь Москва төвтэй Орос орны эзэн хаан бол хуучны Ромын болон Константинополийн эзэн хааны орыг залгамжилж гарч ирсэн хүчирхэг, эрхэм дээд, ариун чанартай эзэн хаан мөн бөгөөд тэрбээр үнэн алдрын шашны сүм хийд, лам хуврагуудыг хараа хамгаалалт, ач ивээл, засаг захиргаандаа багтаасан онцгой чанар, онцгой байр суурьтай хаан мөн гэж Филофей илгээлт бичигтээ үзжээ (1.150). Үүний учир нь эртний үеийн Ром гүрэн, Ромын сүм хийд, Сирийн епископ ламын буруу, тэрс үзлийн гай, харгайгаар нурж унасан бол хоёрдахь Ром болох Константинополь буюу Бурхны хот ба түүний сүм хийд нь агаруудын буруу үзэл санаа, буруу үйл ажиллагааны харгайгаар хаагдаж нурж унасан бөгөөд тиймээс одоогийн шинэ, гуравдахь Ром болох Москвагийн вант улс, түүний их Ван, эзэн хааны хаанчлалын үе ирсэн ба тэрбээр дэлхийн үнэн алдрын шашинт бүх улс орон, үнэн алдрын шашинт нийт хүн ардыг өөртөө татаж, тэдгээрт нар мэт гэрэл гэгээ цацруулж байгаа ажээ. Тиймээс Москвагийн вант улсын их ван л тэнгэр доорх нийт христын шашинтнуудын цорын ганц жинхэнэ эзэн хаан нь мөн ажээ.

Хоёрдугаарт, Филофей Москва төвтэй Орос орны эзэн хааны засаглал, дээд эрх мэдэл нь нийт Орос оронд бүрэн хүчин төгөлдөр, хууль ёсны юм гэсэн санааг гаргажээ. Филофей гуравдугаар Василийд илгээсэн бичигтээ Оросын Ван, хаадын удам угсаа, үе залгамжлал нь Византи гүрний эзэн хаадаас уламжлалтай болохыг заагаад Василий ванд агуу их Константин, ариун хутагт Владимир, бурхны таалалд нийцсэн агуу их Ярослав ба бусад их хаадын үлгэр жишээгээр улс орноо засаглан захирахыг захиж зөвлөжээ. Гуравдугаарт, Филофей эзэн хааны засаглал, дээд эрх мэдэл бурхнаас илгээгдсэн, бурханаас гарал үүсэлтэй гэсэн үзэл санааг чухалчлан өгүүлжээ. Тэрбээр “эзэн хааныг бурхан тохоож тавьсан”, “эзэн хааны зүрх сэтгэл бурхны гарт буй бөгөөд эзэн хаан бурхны боол мөн” гэжээ. Бурхан эзэн хааныг гэм буруу, нүгэл, гэмт хэрэг үйлдэгсэдийг шийтгэж гэсгээн цээрлүүлэх үүрэгтэй болгож тогтоосон, эзэн хаан бол эрхэм дээд, бүхнийг захирагч, бурхны таалалд бүрнээ нийцсэн христын шашны эзэн хаан ажээ.

Дөрөвдүгээрт, Филофей эзэн хааны үндсэн үүрэг, гол зорилго, зорилтуудыг тодорхойлон заажээ. Эзэн хаан бол юуны өмнө өөрийнхөө албат ардад анхаарал халамж тавих үүрэгтэй, тэдэнд өрөвч сэтгэлээр, бас шударга хандах, уйлж гашуудагсадыг тайтгаруулах, гомдож гутрагсадын сэтгэлийг засах ёстой гэжээ. Филофей Василий ванд илгээсэн бичигтээ харамч, хахир хатуу сэтгэлээ өөрчилж өглөгч, өгөөмөр байхыг өвдөг сөгдөн гуйжээ. Эзэн хаан нэг талаар тийнхүү албат ардыгаа энэрч хайрлах, асарч тэтгэхийн хамт нөгөө талаар төр засгийн хүч албадлага ба шашны хүч нөлөө, бурхны гэсгээн цээрлүүлэлтээр засаглан захирч дэг журамтай, сахилга бат, ёс заншилтай байлгах үүрэгтэй ажээ. Хэрэв эзэн хаан албат ард, хүн амыг тийнхүү засаглан захирахгүй юм бол эзэн хаан өөрөө бурхны хатуу ширүүн гэсгээл шийтгэлд өртөхөөр барахгүй түүний төр улс гол усны гашуун зовлонд умбана, тухайлбал, газар хөдлөлт, үер, гал түмэрт автагдана гэжээ. Филофей үүгээр улс орон, түүний хүн ард нь төр засгийн хүчин чадал, хууль цааз, сахилга, дэг журмын хүчээр л хэвийн оршиж тогтоно, хэрэв эзэн хааны засаглал сул, эзэн хаан өөрөө гэм буруутай, дутагдалтай байх аваас улс орон, хүн ард задгайрч, садар самуун явдал газар авна гэсэн чухал үзэл санааг гаргаж илэрхийлсэн байна.

Тавдугаарт, Оросын эзэн хаан төр улс, хүн ардыгаа засаглаж захирахдаа дан хүч албадлага, эд баялаг, алт мөнгөнд найдаж тулгуурлах биш, харин оюун ухаан, соёл, оюуны үнэт зүйлд тулгуурлах ёстой. Тэгсэн цагт л Москвагийн вант улс нь хүчирхэг болно, зүгээр нэг дарангуй, сүр хүчтэй, эртний дарангуй Ром шиг эзэнт гүрэн байхгүй, харин оюун санааны хүчин чадалд тулгуурласан ариун Орос

орон байх болно гэж Филофей үзжээ. Филофей энэ талаар «Алт, эд баялаг, алдар хүндэд бүү найд, тэдгээр нь энэ газар дэлхийд хуримтлагдаж, газар шороонд хөсөр хаягдаж үлдэнэ. Аливаа гэм нүглийн эх үндэс бол мөнгөнд шунах явдалд оршино. Тэнгэр бурхныг хайрлах хайр, итгэх итгэл бишрэл л чухал» гэжээ.

Зургаадугаарт, Филофей албат ард, төр улсын харъяат иргэд, хүн ам эзэн хаанд үг дуугүй бүрэн захирагдах, тэгэхдээ андгайлан тангараглах, үйлдсэн хийсэн гэм нүглээ наминчлах ёстой, хэрвээ эзэн хаан хэн нэгнийг андуу ташаа шийтгэж гомдоовол, хохироовол тэр хүн түүнийг дотроо хадгалж гэсэн тэвчиж өнгөрүүлэх хэрэгтэй гэжээ.

Долдугаарт, эзэн хааны нэгэн чухал үүрэг зорилго бол үнэн алдрын шашин, түүний сүм хийд, лам хуврагуудын төлөө анхаарал халамж тавих явдал мөн ажээ. Филофей Василий Ванд «ариун дагшин сүм хийдүүдийг хоосон эзлүүд байлгаж болохгүй, тэдгээрийг лам хуврагуудаар дүүрэн байлга, лам хуврагуудыг бүү гомдоо, сүм хийдүүдийг бүү хохироо» гэж учирлан гуйж захижээ. Тэгэхдээ Филофей шашин, сүм хийд, лам хуврагууд эзэн хаан, төр засагт захирагдах ёстой, эзэн хаан ба төр засгийн дэмжин түшиж туслах ёстой гэж үзжээ. Гэхдээ сүм хийд өөрийн эрх ашгаа зөв, зүй зохистой хамгаалах хэрэгтэй, лам хуврагууд ван, засаг төрийн өндөр албан тушаалтнуудын алдаа буруу, гэм нүглийг илэн далангүй хэлж илчлэх эрх чөлөөтэй байх ёстой гэсэн санааг Филофей гаргажээ (4.199).

Наймдугаарт, Филофей өөрөө сахил санваартай, ёс журам, уламжлал, сахилга батыг эрхэмлэсэн лам хүн байсан учраас нийгмийн ёс суртахуун, хүн ардын аж төрөх ёс, зан араншин, ичих зовох, буян ба нүглийн асуудалд ихээхэн анхаарал хандуулж тухайн үеийн Орос оронд хүмүүсийн ёс суртахуун, гэр бүл, эхнэр нөхөр, үр хүүхдийн хоорондын харилцаанд гарч байсан гэм нүгэл, алдаа завхралыг ихэд жигшиж, тэдгээрийг таслан зогсоохыг эзэн хаанаас хүсэж гуйжээ. Филофей гуравдугаар Василий ванд илгээсэн бичгээ "эх захаа алдсан содомын садар завхай явдлыг засах тухай" гэсэн гарчигтайгаар илгээсэн нь санамсаргүй явдал биш юм.

Есдүгээрт, Филофей улс орныг удирдах, хүн ардыг засаглаж захирах асуудлын хүрээнд төр засгийн зүгээс хүн ардад үзэл суртал, оюун санааны хэрэгсэлүүдээр зорилго чиглэлтэйгээр нөлөөлөх асуудалд багагүй анхаарал хандуулсан байна. Тухайлбал, Филофей хүн ардын оюун санааны эрх чөлөөнд хязгаар тавих, нэн ялангуяа шинжлэх ухаан, судалгаа шинжилгээг чөлөөтэй байлгахыг эсэргүүцжээ. Филофей бодит ертөнц, бодит амьдралыг хүсэж санасанаар өөрчилж хувиргах байтугай судалж танин мэдэх явдал хүртэл нүгэл, алдаа буруутай үйлдэл болно гэж заажээ. Шинжлэх ухаанаар зөвхөн энгийн жирийн хүн ард төдийгүй ван, хаад, ноёд, лам хуврагууд ч гэсэн оролдож болохгүй, шинжлэх ухаан бол хэн хүнд хаалттай, хор холбогдолтой зүйл гэжээ. Филофей христын шашин үүсэхээс өмнөх үеийн нийгэм, соёл, эрдэм мэдлэгийн ач холбогдол үнэ цэнийг үгүйсгэжээ. (4.201) Филофей эрдэм ухаан, эрдэмтэн судлагчдаас хүн могойноос айж зугатдаг шиг айж зугтахыг хүн ардад зөвлөжээ. Бүхий л эрдэм мэдлэг, оюун ухааны эх ундарага, сан хөмрөг бол бурхны үг болох Библи судар мөн гэж үзжээ.

Дээр өгүүлснийг тоймлож дүгнэвэл Филофей лам бол XV зууны хоёрдугаар хагас, XVI зууны эхний хагасын үед аж төрж үнэн алдрын шашинд хүчин зүтгэж, бас тухайн үеийн Орос орны нийгэм, улс төр, оюун санааны амьдралын үзэгдэл, үйл явдлуудыг гярхай ажиглан харж, тэдгээрт өөрийн үнэлэлт дүгнэлтийг өгч, бодож сэтгэж байсан гүн ухаантан, нийгэм улс төрийн сэтгэгч байжээ. Филофейн нийгэм-улс төрийн үзэл нь тухайн үеийн Орос орон, түүний дотор Москвагийн Вант улсын нийгэм-улс төрийн бодит амьдрал, түүний ирээдүйн эрх ашиг, хэрэгцээ шаардлагын тусгал болж бүрэлдэн төлөвшиж, аажмаар түүний гурван удаагийн илгээлт бичигт тусаж томъёологдсон байна.

Филофейн дэвшүүлж тавьсан улс төрийн гол үзэл санаа бол урьд өмнөх үед тархай бутархай байсан, түүний харгайгаар Монголчуудын довтолгоон, эзлэн түрэмгийлэлд өртөж бараг хоёр зуу гаруй жил тэдний ноёрхол дор байсан, XV зууны үеэс чөлөөлөгдөж Москва төвтэй бие даасан, эрх чөлөөт хүчирхэг улс орон болох бололцоо, зам мөр нь нээгдсэн Орос орон цаашдаа үнэн алдрын шашин, сүм хийдийн дэмжлэгт тулгуурлаж хүчирхэг, шинэ, орчин цагийн гуравдахь Ром бүхий төвлөрсөн, бүхнийг захирсан жинхэнэ эзэн хаантай ариун Орос гүрэн болж хөгжин мандах ёстой гэсэн үзэл санаа мөн болно.

Оросын эзэн хаан улс орноо хүчирхэг, чадалтай, оюун санааны хүч, эрхэмлэл, үнэт зүйлд тулгуурласан ариун гүрэн болгохын тулд үнэн алдрын шашин, сүм хийдэд тулгуурлах ёстой, бас төрийн засаглал, сахилга, дэг журам, хүн ардын ёс суртахуун, ёс заншлыг хатуу чанд дэглэж удирдах ёстой гэсэн санааг Филофей гаргажээ.

Тэрбээр нэг талаас эзэн хааны үүрэг, зорилго, эрх мэдлийг, нөгөө талаас албат ардуудын үүрэг зорилгыг тодорхой заажээ.

Филофей үгэн алдын шашин бол шрын гани үгэн зөв, ариун шашин мөн бөгөөд энэ шашин улс орон, ард олныг үгэн зөв зам мөрөөр замнуулж сэргээж мангуулагч шашин мөн, гэхдээ шашин сүм хийд нь төрд, эзэн хаанд захирагдах ёстой, тэгэхдээ өөрийн эрх шийг, эрх чөлөөг бас хамгаалдаг, эзэн хаан, ноёдоод хэлэх ёстойг зүйлийг иргэн далангүй хэлдэг, түүний ацлаа дутагдлыг шүүмжлэж засаж залруулахад тусалдаг байх ёстой гэсэн санааг чукалчиж гаргасан байна.

Филофей "хүхэм таа Москвагийн Вант улс д үгэн алдын шашны өмөг түшиг, хамгаалж өмгөөлөгч, бас түүнд тулгуурлагч байх ёстой, мөн христын шашинтай бусад улс гүрэн, ард түмнийг дэмжиж хамгаалдаг, гэтэлд христын шашны үгэн алдын сүм хийдийн гэрэл гэгээг цацруулж дэмжлэг үзүүлэгч байх ёстой гэж үзжээ.

Судлаач эрдэмтэлчирээдүйн гуравдахь Ромын талаарх үзэл санаа зөвхөн XVI зуунд, тэр дотор зөвхөн Филофей ламын гаргаж тавьсан үзэл санаа биш, энэ тухай үзэл санаа Византи гүрний үеийн инийгэм- улс төрийн сэтгэгчид ч тэдгэрхэй хэмжээгээр тавигдаж байсан, харин Филофейн үзэл санааны үгэн шийг, ач холбогдол нь гурав шихь Ромын тухай үзэл санааг XVI зууны үеийн Орос орны гүүхэн шийг нөхцөл байдалтай нягт уялдуулж, шинэ байдлаар дэвшүүлэн тавьсанд оршино гэж үзсэн байна.

Зарим судлаачид "Москва гуравдахь Ром" гэсэн үзэл баримтлал, ялангуяа Филофейн улс төрийн үзэл санааны Орос орон шинэ шийг Ром гүрэн болж хүчирхэгжин бусад улс орон, ард түмнийг түрэмгийлэн эзлэх ёстой гэсэн дала үзэл санааг асуулсан гэж үздэг нь бодит үнэн үл иийгшг, тийм үгэл нь ацлаа буруутай, Филофейн улс төрийн үзлийн гол утга санаа бол Орос орон шашин ба төр нь бие биег түшиг туссан, оюуи саншны хүчин чадал, оюуи ухааны үгэн зүйлийг эрхэмлэсэн хүчирхэг бөгөөд ариун Орос гүрэн болох ёстой, тэгвгээрээ христын шашинг бусад улс орон, ард түмэнд өмөг түшиг болох ёстой гэсэн үзэл санаа мөн гэж мэргэжлийн судлаач эрдэмтэд дүлжж үзсэн байна.

Филофей өөрийнхөө улс төрийн үзэл санааг "Москва гуравдахь Ром" хэмээн шууд нэрлэж, улс төрийн нэгтгэл үзэл баримтлал гэж үгэж байгаагүй ажээ. Филофейн улс төрийн энэхүү үзэл санаа нь тэр үеийн Орос орны хөгжил, ирээдүйн хэрэгцээ шаардлага хийгээд бусад сэтгэгч мэргэд, хүн ардын үгэл ухмысарт иийгшж уялдам учраас хөгжмийн үгэн нэхэм нөлөөтэй болж өргөн дэлгэрэл ба дараагийн үеийн Оросын сэтгэгчид түүнийг сэлбэн байжуулснаар "Москва гуравдахь Ром" хэмээх улс төрийн үзэл баримтлал бүрэлдэж боловерчгасон байна. Филофейн улс төрийн үзэл санаа ба "Москва гуравдахь Ром" хэмээх улс төрийн үзэл баримтлал нь дараачийн үеийн Оросын улс төрийн сэтгэгчид багагүй нөлөөлж өөрийн ул мөрөө дол үлдээжээ.

Ашигласан ном зохиолын жагсаалт

1. Анталогия мировой политической мысли. Т.3. М., 1997.
2. Всемирная история. Под ред. академика Г.Б. Поляка и профессора А.Н. Марковой. М., 2000.
3. Галактионов А.А., Никандров П.Ф. Русская философия IX-XIX вв. 2-ое изд. Ленинград, 1989.
4. История политических и правовых учений. Под общ. ред. академика В.С. Нерсесянца. М., 1997.
5. История политических и правовых учений. Под общ. ред. профессора О.Э. Лейста. М., 2000.
6. Тонких В.А., Ярецкий Ю.Т. История политической и правовой мысли России. М., 1999.
7. Политическая история России. М., 1998.
8. Российская история. Под ред. академика Г.Б. Поляка. М., 1997.